

ХҮН АМЫН ДУНД ЭМИЙН ҮНЭ, ЧАНАР, ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААРХ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын
Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газар

Зорилго

Эмийн бүтээгдэхүүний үнэ, чанар, хүртээмж, зохистой хэрэглээний өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, ард иргэдийг чанартай, боломжийн үнэтэй эмээр тэгш хүртээмжтэй хангахын тулд цаашид авах арга хэмжээг тодорхойлох юм.

Үндэслэл

Монгол улсын эрүүл мэндийн санхүүжилт нь холимог тогтолцоотой буюу улсын төсөв, эрүүл мэндийн даатгал болон иргэний шууд төлөх төлбөрөөс бүрддэг. Гэвч 2020 оны байдлаар хувь хүн халааснаасаа гарган шууд эмэнд зарцуулах төлбөрийн хэмжээ 40 хувь байна ¹. ДЭМБ-ын зөвлөмжөөр иргэний шууд төлөх төлбөрийн хэмжээ 25 хувиас хэтэрвэл ядуурал ихэсч, орлогоос хамаарсан тэгш бус байдал үүснэ гэж үзэж байна ². Иргэд шууд төлөх төлбөрийн ихэнх хувийг эмчилгээний зардал, оношилгоо болон эм худалдан авахад зарцуулж байна ³. Эрүүл мэндийн салбарын төсөвт ДНБ-ны 5-6 хувийг зарцуулах нь зохистой гэж ДЭМБ-аас үздэг хэдий ч манай улсын хувьд дөнгөж 2.6 хувийг зарцуулж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм ⁴.

Манай улсын хувьд иргэний шууд төлөх төлбөрийн хэмжээг бууруулах, эрүүл мэндийн салбарын зардалд эзлэх ДНБ-ний хэмжээг өсгөх, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулах зэрэг нь тулгамдаж буй асуудал хэвээр байгаа бөгөөд төрийн зохицуулалт бодит оролцоо үгүйлэгдэж байна.

Иймд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль шинэчлэн батлагдахтай холбогдуулан эмийн үнийн зохицуулалтад төрийн оролцоо шаардлагатай эсэхийг үнэлэхийн тулд улсын хэмжээнд хүн амын дунд эмийн чанар, хүртээмж үнийн асуудлын өнөөгийн нөхцөл байдлыг судлах шаардлага бий болсон.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас 2021 оны 04 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 15-ны хооронд Улаанбаатар хот, 21 аймгийн хэмжээнд олон нийтийн сүлжээ болон монголын үүрэн телефоны оператор компаниудаар дамжуулан асуумж судалгаа явуулсан.

Үр дүн

Судалгаанд нийт 7517 хүн хамрагдсаны 72.9% нь Улаанбаатар хот, 27.9% нь хөдөө, орон нутгийн иргэд байсан бол ихэнх хувийг эмэгтэй (72.6%), 30-34 (16.8%) насны бүлэг эзэлж байсан.

1. Эмийн чанар

Судалгаанд хамрагдсан иргэдийн 45.8% нь эмийн чанарыг харгалзан сонголт хийдэг ч гэсэн, 50.6% нь эмийн чанарт эргэлздэг, 41.4% нь эмийн чанарт итгэдэг байна.




График 1. Та эм авахдаа юу анхаарч сонголт хийдэг вэ ?




График 2. Та эмийн сангаас эм худалдаж авахдаа чанартай гэдэгт итгэлтэй байдаг уу?

2. Эмийн зохистой хэрэглээ

Оролцогчдын 77.8% нь эмчийн заавраар, 29.5% нь эм зүйчийн санал болгосноор эмийг худалдан авдаг бол 17.1% нь бусдын санал болгосноор олон нийтийн сүлжээний зар сурталчилгаа болон өөрөө дур мэдэн эмээ сонгон хэрэглэдэг байна. Мөн судалгаанд хамрагдагсдын 50-аас дээш хувь нь эм худалдан авахдаа хэрэглэх заавар болон бусад шаардлагатай мэдээллээ хангалттай авч чаддаггүй.




График 4. Та эмийн сангаас эм худалдаж авахдаа хэрэглэх заавар болон өөрт шаардлагатай мэдээллээ авч чаддаг уу?

3. Эмийн үнэ

Оролцогчдын 47.7% нь эмийн үнэ хэт үнэтэй 38.4%, нь үнэтэй, 13.2% нь боломжийн үнэтэй гэж хариулсаныг график 5-д харуулсан байна. График 7-д үзүүлснээр оролцогчдын 19.8% нь шаардлагатай эмийг санхүүгийн хүндрэлд орохгүйгээр худалдан авч чаддаггүй, 55.9% нь зарим тохиолдолд шаардлагатай эмийг хүндрэлгүйгээр авч чаддаггүй гэж

хариусан бол нийт оролцогчдын 24.4% санхүүгийн хүндрэлгүйгээр шаардлагатай эмийг худалдан авч чаддаг байна. График 6-д харуулсан байдлаар оролцогчдын 19.8% нь үнэ, өртөгөөс хамаарч эмийг худалдаж аваагүй тохиолдол байхгүй, 46.8% нь жоронд бичсэн эмийг үнэ, өртөгөөс хамааран худалдаж аваагүй тохиолдол байгаа ба харин 34.3% нь зарим тохиолдолд авч чаддаггүй гэж хариулсан байна. Эндээс харахад судалгаанд оролцсон 7517 оролцогчдын 70-аас дээш хувь нь жоронд бичсэн эмийг үнэ, өртөгөөс хамраарч худалдаж аваагүй тохиолдол гарч байгаа нь манай улсын зах зээлд борлуулагдаж буй эмий үнэ харьцангуй өндөр байж болох ч нөгөө талаараа иргэдийн эмийн хэрэглээ өндөр байх хандлагатай байна. График 8-д үзүүлсэн үр дүнгээс харахад оролцогчдын 8.0% нь эмийн үнийг зохицуулахад төрийн оролцоо хэрэггүй, 13.3% нь мэдэхгүй гэж хариулсан бол 78.6% нь эмийг үнийг зохицуулахад төрийн оролцоо хэрэгтэй гэж үзэж байгаа нь шийдвэр гаргалтад нөлөөлж болохуйц өндөр үзүүлэлт харагдаж байна.

График 5. Манай улсын зах зээл дээр борлуулагдаж байгаа эмийн үнийг юу гэж бодож байна?




График 6. Та жоронд бичсэн эмийг үнэ, өртөгөөс хамаарч худалдаж аваагүй тохиолдол байгаа юу?





График 7. Шаардлагатай эмийг санхүүгийн хүндрэлд орохгүйгээр худалдан авч чаддаг уу?



График 8. Эмийн үнийг зохицуулахад төрийн оролцоо хэрэгтэй юу?



Иргэдийн санал /нээлттэй/

Уг судалгаанд өрхийн орлогын дундаж түвшиний иргэд давамгайлсан (500 мянгаас 1 сая төгрөгний орлоготой иргэд 41.2%) хамрагдсан бөгөөд эмийн сангуудад нэг төрлийн эм өөр өөр үнээр борлуулагддаг, эмчийн жоронд бичсэн бүх эмийг худалдаж авахад санхүүгийн хувьд хүндрэлтэй байдаг бөгөөд эмийн үнийг төрөөс хянах, зохицуулах

шаардлагатай гэж үзсэн. Үүнээс гадна шаардлагатай, оновчтой эмийг эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй олгох эмэнд багтаах нь чухал болохыг сануулсан.

Мөн нэг удаагийн эмчилгээнд удаан хугацаанд олон төрлийн эм хэрэглэхэд хүрдэг нь магадгүй эмийн чанар тааруу байж болзошгүй гэж олонхи иргэд саналаа ирүүлсэн.

Дүгнэлт

Судалгааны зорилтын хүрээнд эмийн чанар, үнэ, зохистой хэрэглээг үнэлэхэд хүн амын дунд эмийн зохистой хэрэглээний ойлголт харьцангуй сайн үзүүлэлттэй буюу 77.8% нь эмчийн заавраар эмийг хэрэглэдэг бөгөөд 70-аас дээш хувь нь эмийн заавар зөвлөмжийн дагуу эмийг хэрэглэх хандлагатай нь ажиглагдаж байна.

Иргэд эмийг сонгохдоо эмийн чанарыг голчлон анхаардаг ч, худалдаж авч буй эмийнхээ чанарт 50.9% нь эргэлздэг байна. Хэдийгээр эмийн чанарт эргэлзэх хувь өндөр байгаа ч зах зээл дээрх эмийг шууд чанаргүй гэж үзэх нь өрөөсгөл юм. Иймд бид эмийн чанарын асуудалд анхаарал хандуулж хяналт, үнэлгээг сайжруулах шаардлагатай.

Зах зээлд борлуулагдаж буй эмийн үнийг хэт үнэтэй (38.4%) болон үнэтэй (47.7%) гэж үзсэн бөгөөд 46.8%-80.1% нь зарим тохиолдол жоронд бичсэн эмийн үнээс хамаараад худалдаж авч чадахгүй тохиолдол гардаг байна. Мөн судалгаанд хамрагдсан иргэдийн 24.4%-аас бусад нь шаардлагатай эмийг санхүүгийн хямралд орохгүйгээр худалдаж авахад асуудал тулгардаг нь харагдаж байна. Эндээс харахад Эм, Эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.2-т заасан эмийн үндэсний бодлогын ⁵ хэрэгжилт төдийлөн хангалттай биш байна.

Монгол улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд эмийн үнэ, эмчилгээний төлбөр өндөр байх нь хүн амын орлого, амжиргааны түвшинд нөлөөлж, орлогоос шалтгаалах тэгш бус байдал үүсч, эрүүл мэндээс шалтгаалах эдийн засгийн хямралд ихээр өртөх тул төрийн оролцоо зохицуулалт зайлшгүй хэрэгтэй. “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого 2020-2026”-д ядуу, эмзэг бүлгийн иргэдийг эрүүл мэндийн улмаас санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлж хамтарсан төлбөр, өндөр үнэтэй эмийн төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх зохицуулалт хийгдсэн байна гэж тусгагдсан ⁶.

Хэдийгээр Монгол улсад эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг төрөөс хариуцдаг, эмнэлгийн тусламж, үйлчилгээг голлон эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлдэг боловч иргэд, нэн ялангуяа даатгалгүй, болон ядуу иргэд эрүүл мэндийн үйлчилгээ авахын тулд халааснаасаа шууд мөнгө төлөх асуудалтай байнга тулгардаг ¹.

Гэвч хүн амын эрүүл мэндийг сайжруулах нь өвчилсөний дараа эмчлэх гэж эмийн үнэ, эмчилгээний төлбөр зэрэг асуудалд гол төсөв хөрөнгийг чиглүүлэх биш өвчлөхөөс урьдчилан сэргийлэх арга болох нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ, анхан шатны эрүүл мэндийн мэдлэг боловсролыг сайжруулж, хүүхдэд багаас нь амьдралын зөв хэв маягийг төлөвшүүлэх хэрэгтэй зэрэг асуудал тулгарч байна.

Иймд Эм, Эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар байгуулагдсан нь иргэдийг боломжийн үнэтэй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах, иргэдийн эмийн зохистой хэрэглээ болон эрүүл мэндийн мэдлэгийг сайжруулах үйл ажиллагааны цогц систем бий болох боломжтой гэж үзэж байна.

Ном зүй

1. МОНФЕМНЕТ. Эрүүл мэндийн даатгал, санхүүжилтийн тогтолцоо. 2020.
2. WHO. Global Monitoring Report. 2019.
3. ADB. Санхүүгийн хямралын үед ядуу иргэдэд хүргэх эрүүл эрүүл мэндийн тусламж үйлчилгээг баталгаажуулсан нь. 2016.
4. Empirical Analysis of Relationship between Per Capita Health Expenditure and Economic Growth Based on Vector Autoregressive Model (VAR) in Mongolia. Uranbileg, Bayarbat. 01, Theoretical Economic Letter, 2020 , 10.
5. ЭМС.Эм, Эмнэлгийн хэрэгслийн тухай хууль. УБ: 2010.
6. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого 2020-2026. 2020.